



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 06 өдөр

Дугаар А/536

Булган сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1, 31 дүгээр зүйлийн 31.4 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 14 дүгээр хуралдааны 14/01 тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган сумын нийтийн эзэмшлийн зам, талбайн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, орчны тохижилтыг сайжруулах зорилгоор Хангал сумын Хялганат тосгоны өндөр хүчдэлийн шугаман доорх газраас 25 ширхэг нарс мод шилжүүлэн суулгахад 3,500,000 (гурван сая таван зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Тус арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг Байгаль хамгаалах сангийн “Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, зам талбайн засвар арчлалт” төсөл арга хэмжээнээс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

3. Мод шилжүүлэн суулгах төсөл арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлж, хяналт тавин ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (А.Гантөмөр)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2023 оны
07 дугаар сарын 06-ны өдрийн А/536 дугаар
захирамжийн хавсралт

НАРС ШИЛЖҮҮЛЭХ АЖЛЫН ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Зардлын нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэ	Нийт
Тулгуур бэлтгэх					
1	Тулгуур мод	75	ширхэг	1,300	97,500
2	Тулгуур мод зөөх портер	1	ширхэг	90,000	90,000
3	Төмөр утас	3	боодол	5,000	15,000
4	Зөөлөвч материал	5	ширхэг	5,000	25,000
5	Эксковаторын хөлс	1 цаг	мот/цаг	180,000	180,000
6	Үндэс боох таар	4	боодол	95,000	380,000
7	Үндэс боох уяа	25	ширхэг	5,000	125,000
Нарсыг сийрүүлж авах					
8	Ажилчдыг зөөх шатахуун	34	литр	3,550	120,000
9	Масло	1	литр	22,000	22,000
10	Ажилчдын хөлс /гэрээгээр/	6 хүн	2/өдөр	150,000	900,000
11	Нарс модыг тээвэрлэх /машины хөлс/	2	машин	300,000	600,000
12	Нарс модыг өргөж ачих /кран/	1	машин	500,000	500,000
Усалгаа					
13	Усалгааны ажлын зардал	2*5	хоног	30,000	300,000
14	Мод тарих нүх услах шатахуун	41	литр	3,550	145,500
Бүгд дүн					3,500,000